



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№56 /500/

2023.04.05

Цаг үе, үйл явдал

Ж.БОЛДБААТАР: ӨРГӨСӨН ТАНГАРАГ, ЭРХЭЛСЭН АЖИЛДАА ҮНЭНЧ, ШУДАРГА БАЙХЫГ ЭНЭ ЦАГ ҮЕ БИДНЭЭС ШААРДАЖ БАЙНА



Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласан билээ. Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний нэг хэсэг болгох замаар ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэгч төрийн албыг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн байдаг.

Эдгээртэй уялдуулан Батлан хамгаалах яам, Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын алба хаагчдыг хамрууллаа.

Эл сургалтаар “Авлигын хор хөнөөл, шалтгаан нөхцөл”, “Авлигын гэмт хэрэг”, “Ёс зүйтэй шийдвэр гаргалт”, “Хувь хүний хөгжил, манлайлал, харилцаа хандлага” зэрэг сэдвийг хөндөж, илтгэл хэлэлцүүлэг өрнүүлэв. Энэ удаагийн сургалтын зорилго нь Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэрэг, тус гэмт хэргийн шалтгаан

нөхцөл, үр дагаврыг ойлгох, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх хандлагыг алба хаагчдадаа таниулах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх, нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм.

Сургалтыг дүгнэж Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар хэлсэн үгэндээ “Өргөсөн тангараг, эрхэлсэн ажилдаа үнэнч, шударга байхыг энэ цаг үе биднээс шаардаж байна. Иймд орон нутгийн захиргааны байгууллагад батлан хамгаалах салбараа төлөөлөн ажиллаж буй та бүхэн сахилга хариуцлагаараа ямагт үлгэрлэгч байх ёстой” хэмээгээд дараах чиглэлийг ажил албандаа мөрдлөг болгохыг үүрэг болголоо.

Тодруулбал, Авлигын эсрэг түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, авлигатай тэмцэх сургалт, сурталчилгааг алба хаагчдынхаа дунд зохион байгуулах, нууцаас бусад үйл ажиллагаагаа ил тод нээлттэй байлгах, иргэдийн өргөдөл, гомдол,

хүсэлтийг хуулийн хүрээнд шударга шийдвэрлэх, шат дамжлагыг цөөрүүлэх,

-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, энэ талаарх ажил арга хэмжээг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, цэрэг татах үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, авлига, албан тушаалын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх,

-Авлигатай холбоотой мэдээлэл, авлига өгсөн, авсан үйлдлийг мэдсэн тохиолдолд БХЯ-ны эрх бүхий албан тушаалтанд болон Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх, авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах,

-Аливаа эрсдэлийг тооцож, гарч болох зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагад анхаарч, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатайг онцолсон юм.

Дэслэж Ө.НАСАНТОГТОХ

ДУЛААНЫ УЛИРЛЫН ДҮРЭМТ ХУВЦСАНД ШИЛЖИНЭ



Дулааны улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэх тухай Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаал батлагджээ. Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч нар 4 дүгээр сарын 10-ны өдрөөс, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нар 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дулааны улирлын дүрэмт хувцсанд шилжинэ.

Дулааны улирлын дүрэмт хувцсанд шилжихтэй холбогдуулан Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад хувцасны үзлэг явагдаж, тайлан мэдээллийг ЗХЖШ-т хүргүүлнэ.

Мөн Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Онцгой байдал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд алба хаагчдынхаа ажил үүргийн онцлогт нийцүүлэн дулааны улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэх хугацааг дотооддоо тогтоож, мөрдүүлэх талаар тушаалд тусгагдсан байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	28

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,510	3,515
EUR	3,845	3,875
CNY	511	513.50
RUB	44.10	44.80
JPY	26.75	26.95
KRW	2.70	2.72

ЗУРХАЙ



2023.04.05 /ЛХАГВА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 15

**ХАВРЫН ДУНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд мал арвидна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.23-19.27

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглалвал эд агуурс олох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олноо.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 684,289,335

Эдгэрсэн

Нийт: 657,255,870

Нас барсан

Нийт: 6,833,794

Цаг үе, үйл явдал

ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН АХМАДУУДЫН ТЭМЦЭЭН ӨРСӨЛДӨӨН ДУНД ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Монгол Цэргийн Нэгдсэн Холбоо үүсэн байгуулагдсаны 4 жилийн ойг тохиолдуулан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын ахмадуудын дунд зохион байгуулж буй спортын цогцолбор тэмцээний нээлтийн ёслолын ажиллагааг өнөөдөр "Алдар" спорт хорооны спортын их танхимд зохион байгуулав.

Тэмцээний нээлтийн ёслолд МЦНХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, тус холбооны Ажлын албаны дарга бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн, Ажлын албаны ажилтан гавьяат хуульч, цагдаагийн хурандаа Ж.Бумнанжид, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын Ахмадын хорооны дарга нар, тэмцээнд оролцож баг, тамирчид, хөгжөөн дэмжигчид оролцсон юм.

Энэ үеэр Монгол Цэргийн Нэгдсэн Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга дэслэгч генерал Ц.Тогоо хэлсэн үгэндээ "МЦНХ байгуулагдсанаас хойш 4 жилийн хугацаанд нийт 400 гаруй ажил, арга хэмжээг зохион байгуулж, нэг сая гаруй хүн хамрагдсан байна. Ирэх жил тохиох 5 жилийн ойгоороо хилчин хүн жилийн дөрвөн улиралд байгаль, цаг уурын хүнд нөхцлийг туулж эх орныхоо дархан хилийг хамгаалдаг, цагдаа, онцгой байдлын

алба хаагчид эрсдэлт хүчин зүйлийг эрэлхгээр давж, хүн ардынхаа аюулгүй байдлыг сахин хамгаалж ирсэн, Зэвсэгт хүчний дайчид алжааж ядрахыг үл хайхран хилийн чанадад энхийг сахиулах үүргээ нэр төртэй биелүүлж буйг ард иргэддээ ойлгуулах өргөн цар хүрээтэй ажлыг зохиохоор төлөвлөж байгаа" гэв.

Мөн уг нээлтийн ёслолын үеэр өмнөх өдрүүдэд энэхүү цогцолбор тэмцээний хүрээнд зохион байгуулсан шатар болон билиардын тэмцээний шагналыг гардуулж, баяр хүргэлээ.

Энэхүү цогцолбор тэмцээний шатрын тэмцээнд Тагнуулын Ерөнхий газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цагдаагийн Ерөнхий газрын баг тамирчид эхний 3 байрыг эзэлсэн юм.

Харин билиардын тэмцээний төрөлд Цагдаагийн Ерөнхий газар, Шүүх шинжилгээний Ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын Ерөнхий газрын багууд тэргүүлж цом, медаль, мөнгөн шагналын эзэд болов.

Энэ өдөр БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны их танхимд волейболын тэмцээн ширүүн өрсөлдөөнтэй явагдаж, одоогоор Монгол Цэргийн Нэгдсэн Холбоо, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тагнуулын Ерөнхий газрын Ахмадын хорооны баг, тамирчид аварга төлөө өрсөлдөж байна.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ДОТООДЫН ЦЭРГИЙН 805 ДУГААР АНГИЙНХАНД СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит "Түвшин тогтоох үзлэг" төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд явагдаж буйтай холбогдуулан ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийнхан ээлжит сургалтаа Дотоодын цэргийн 805 дугаар ангид 4 дүгээр сарын 4-ний энэ өдөр зохион байгуулж явууллаа.

Сургалтаар үзлэгийн ерөнхий

универсальг үндэслээд ямар норматив, шалгуур, шалгалтаар, хэрхэн дүгнэх талаар мэдээлэл хүргэж, төрийн тусгай алба хаагчдын бие бялдраа хөгжүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах, дүрэмт хувцасны зохистой хэрэглээ, ёс зүйн түвшнийг дээшлүүлэх үндсэн зорилготойг онцлолоо. Мөн байгууллагуудын хоорондын нэгдмэл байдлыг сайжруулах ач холбогдолтойг дурдаж, сонирхсон асуултад нь хариулт өгсөн юм.

ЭМГЭНЭЛ САНЖИДЫН МӨНХӨӨ (1946-2023)



нийслэл хот, 18 аймагт энгийн болон цэргийн тусгай зориулалтын бүтээн байгуулалтыг удирдан зохион байгуулахад үүргээ нэр төртэй биелүүлсэн барилгын цэргийн нэр хүндтэй инженер, чадварлаг удирдагчдын нэг байлаа. Тэрбээр Авто засварын завод, Арьс ширний үйлдвэрийн Эрдэм шинжилгээний институтын лабораторийн барилга, Нүхтийн 24 айлын орон сууц, "Оргил" рашаан сувилал, Улаанбаатар хотын Сонсголон, Сонгино цэргийн хүрээ, Төв, Өвөрхангай аймагт цэргийн нэгтгэл, ангиудын цогцолбор хотхонууд, Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн иж бүрэн байгууламж, Налайхын тусгай объектын барилгууд, Одон орон судлалын төв зэрэг олон барилгыг барьж ашиглалтад өгөхөд оролцжээ. С.Мөнхөө нь цэргийн барилгын байгууллагуудын бүтэц, удирдлага, зохион байгуулалт, материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, барилга үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилтыг тоо, чанарын бүх үзүүлэлтээр нь давуулан биелүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг сайжруулахад идэвх санаачилга гарган ажилласан зарчимч, хөдөлмөрч, хүнлэг нэгэн байлаа. Хурандаа С.Мөнхөө Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд хийгдэж байсан шинэчлэлийн бодлогын хүрээнд барилгын цэргийг мэргэшсэн байгууллагын зохион байгуулалтад дэс дараатай шилжүүлж, зах зээлийн харилцаанд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд Барилгын цэргийн Төв штабын үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байсан манлайлагчдын нэг байлаа.

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дэд дарга асан, Монгол Улсын Гавьяат барилгачин, зөвлөх инженер, хурандаа Санжидын Мөнхөө 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр өвчний улмаас нас нөгчсөнд гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, хамтран зүтгэгчдэд нь гүн эмгэнэл илэрхийлэв.

С.Мөнхөө нь 1946 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хотод төрж, 1965 онд Нийслэлийн 18 дугаар сургууль, 1967-1971 онд ЗХУ-ын Ленинград хотын /Хуучин нэрээр/ Цэргийн барилгын дунд сургууль, 1976-1980 онд Москва хотын Куйбышевын нэрэмжит Цэргийн инженерийн академи, 1985 онд Москва хотын Нийгмийн ухааны академийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх курсийг тус тус төгсөж, улмаар техникийн шинжлэх ухааны магистр цол хамгаалжээ.

Тэрбээр 1965-1967 онд Улсын Барилгын зургийн Төв институтын үйлдвэрийн товчоонд зургийн техникч, 1967 онд хугацаат цэргийн алба хаагч, 1971-1983 онд Барилгын цэргийн 083, 073, 021, 012 дугаар ангиудад курсийн дарга, багш, штабын даргын туслах, ерөнхий инженер, ангийн захирагч, 1983-1987 онд Намын Төв хорооны Барилгын хэлтсийн зааварлагч, 1987-1997 онд Барилгын цэргийн Төв штабын дарга, 1997-2001 онд Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дэд дарга, Барилгын цэргийн штабын даргаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ. С.Мөнхөө өндөр насны тэтгэвэрт гарсныхаа дараа 2002-2017 онд хувийн хэвшилд барилгын инженерээр ажиллаж байв. Хурандаа С.Мөнхөө нь барилгын салбарт 50 жил, үүнээс барилгын цэрэгт 35 жил ажиллахаа өргөсөн тангарагтаа үнэнч байж,

У.ХУРЭЛСҮХ, Г.ЗАНДАНШАТАР, Л.ОЮУН-ЭРДЭНЭ, Г.АМАРТҮВШИН, Т.ДОРЖХАНД, Д.САРАНГЭРЭЛ, Г.САЙХАНБАЯР, Ж.БАТБАЯСГАЛАН, Д.СУМЪЯАБАЗАР, С.ГАНБЯМБА

Түүний дараа хамт олонсог байх, нөхдийгөө хүндэтгэх тухай онцолж, цэргийн алба хэдий захирах захирагдах ёсны хатуу зарчимтай ч хүн хоорондын харилцаа заавал зэрэгцэж явах ёстой. Энэ хорвоод сайн, муу хүн гэж байхгүй. Олон их, дээд сургуульд суралцсанаараа бусдаас дээгүүр хүн болчихгүй. Хүн гэдэг статусаараа энэ хорвоод бүгд ижилхэн. Гудамжинд ядруу яваа Батаа, даргын албан тушаалтай Дорж хоёр яг адилхан эр хүн байхгүй юу. Эр хүн өөрийн үүрэг хариуцлагаа ойлгож чадвал амьдрал аяндаа тэгшрээд явчихна гээд яруу найрагч До.Болдхуягийн "Тусгаар тогтнол" шүлгээр сургалтаа өндөрлүүлэв.

Ахмад Д.БОЛОР

ХӨДӨЛМӨРИЙН БААТАР П.ЦЭРЭНДАГВЫН "ХҮН БАЙХЫН УЧИР" СУРГАЛТААР ...



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас "Офицер, ахлагч нарын манлайлын жил"-тэй уялдуулан бие бүрэлдэхүүндээ цэргийн албаны болон хувь хүний хөгжилд чиглэсэн сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж байгаа билээ. Энэ удаа Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Пүрэвдоржийн Цэрэндагвыг урьж "Хүн байхын учир, эр хүн танд хэлэх миний үг" сэдвийн хүрээнд чөлөөт уулзалт ярилцлагыг зохион байгуулав.

Хөдөлмөрийн баатар уулзалтынхаа эхэнд "Цэргийнхэн гэхээр төр л санагддаг, эх орны хүү гэхээр ард түмний хөвгүүд л бодогддог. Эх орныхоо тусгаар тогтнолын баталгаа нь болж яваа золбоо хиймөр салбарын залуустай уулзаж байгаадаа баяртай байна. Ариун жагсаалынх нь цэрэг болох хувь надад тохиогоогүй ч байлдагчаас хошууч генерал хүртэлх дүрийг бүтээж, ард түмэндээ энэ албыг сурталчилсандаа талархаж явдаг билээ" хэмээгээд аав, ээжийгээ хайрлах, ханиа халамжлах, үр хүүхдүүдээ энэрэх, хамт олноо хүндэтгэх зарчмын тухай өөрийн туулж өнгөрүүлсэн амьдралын сургаж дээр үндэслэн өгүүлэв.

"Би эхээс тавуулаа. Дөрвөн настай байхдаа ааваасаа өнчирч, ижий минь нялх хүүхдүүд тэврээд үлдсэн ч аав хэмээх даллага биднийг энэ амьдралд дахин түшсэн хувьтай. Пүрэвдорж гэж агуу аавтай учирсандаа талархаад баршгүй. Ёстой нөгөө гэдэс цагталан, мөр бүтэн өсгөж, бид ч нас биед хүрээд аавыгаа дэргэдээсээ огтхон ч явуулаагүй. Ээж минь ч ялгаагүй, миний шүтэж ирсэн ганц бурхан. Би хэдий бурхангүй үзэлтэн хэдий ч аав, ээжийнхээ тухай ярихаараа тэднийг амьд бурхан байсныг ойлгодог юм. П.Цэрэндагвын төрдөө үнэлэгдэж, түмэндээ хүндлэгдсэн энэ сайхан алдрын эхлэлийг тэд л тавьсан юм" гээд аав хүний хайр үр хүүхдүүдийнх нь хүмүүжлийн гол толь байдгийг санаж, зөв эр хүн байх талаар жишээ татан ярилаа.

Үргэлжлүүлэн ханийн халамжийн тухай өгүүлсэн бөгөөд "Миний амьдралдаа хамгийн их баярлаж явдаг зүйлийн нэг нь ханьтайгаа учирсандаа. Өнөөдөр хоёр биеэ 20 болгон үржүүлж, зээнцрээ үзсэн буурлууд болсон байна. Миний хань ёстой нэг хүний дээд хүн гэмээр эмэгтэй. Би залууст хэлдэг. Та эр хүн л юм бол өрх гэрээ өнгөтэй, өөдтэй авч явах, айлын

охиныг аз жаргалтай амьдруулах нь зөвхөн таниас шалтгаална шүү гэж. Эр хүн ачаа үүрэх гэж төрсөн болохоос биш айлын охиныг гэртээ авчраад "Амьдрал тэгш" гээд барьцаад сууж таарахгүй. Боловсрол хэдий чухал ч хүмүүжил түүнээс ч илүү үнэ цэнтэй. Мэндбаяр бид хоёр гурван хүүхэдтэй. Хоёр охин, нэг хүү. Хүүгээ нас биед хүрэхэд нь нэг л зүйл хэлсэн, гуйсан. "Аав ээж хоёрыгөө нэг л айлын босго давуулаарай" гээд. Энэ нь ханьдаа үнэнч явахыг онцлон захиж хэлсэн аавын үүрэг. Миний хүү Дугаржав гээд мундаг хурандаагийн охинтой амьдралаа холбосон. Одоо сайхан амьдарч яваа" гээд эр хүнд эрэмбэ, хүндлэл, тэвчих, энэрэх олон чанар байх ёстойг тодотгов.

Түүний дараа хамт олонсог байх, нөхдийгөө хүндэтгэх тухай онцолж, цэргийн алба хэдий захирах захирагдах ёсны хатуу зарчимтай ч хүн хоорондын харилцаа заавал зэрэгцэж явах ёстой. Энэ хорвоод сайн, муу хүн гэж байхгүй. Олон их, дээд сургуульд суралцсанаараа бусдаас дээгүүр хүн болчихгүй. Хүн гэдэг статусаараа энэ хорвоод бүгд ижилхэн. Гудамжинд ядруу яваа Батаа, даргын албан тушаалтай Дорж хоёр яг адилхан эр хүн байхгүй юу. Эр хүн өөрийн үүрэг хариуцлагаа ойлгож чадвал амьдрал аяндаа тэгшрээд явчихна гээд яруу найрагч До.Болдхуягийн "Тусгаар тогтнол" шүлгээр сургалтаа өндөрлүүлэв.

...Алтан соёмбо, хөх халзтай улаан далбаа Арга ядарсан ч тусгаар тогтнолтой би баян хүн Ээлж дараатай орчлонгийн жам ямар боловч Эцсээ хүртэл тусгаар тогтнолдоо би эзэн хүн хэмээн сэтгэлийн гүнээс цээж тэнэгэр, омог бардам уншихад нь цэргийнхэн алга ташсаар л байлаа.

Ахмад Д.БОЛОР